**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 12 сарын 16 өдөр Дугаар А/622 Улаанбаатар хот

Багануур дүүргийн Усан спорт, боулингийн
Төвийн эргэлтийн бус хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт болон 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 23,640,050.0 (хорин гурван сая зургаан зуун дөчин мянга тавь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Багануур дүүргийн Усан спорт, боулингийн төв (Б.Олонтүмэн)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 5 нэр төрлийн 11,945,000.0 (арван нэгэн сая есөн зуун дөчин таван мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 1 нэр төрлийн 11,695,050.0 (арван нэгэн сая зургаан зуун ерэн таван мянга тавь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг Багануур дүүргийн Усан спорт, боулингийн төв (Б.Олонтүмэн)-д, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОЮУМАА

1150521850

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/622 дугаар тушаалын хавсралт

## Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багануур дүүргийн Усан спорт, боулингийн төв

| д/д | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | Байгууллагын үнийн санал | НӨХГ-ын мэргэжилтний дүгнэлт | ҮХХХК-ын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Компьютер /программ хангамж шинэчлэлт/ | 10 | ш | 1 | 11,695,050.0 | 11,695,050.0 | 11,695,050.0 | 0.0 | Ашиглах боломжгүй | Актлах | 0.0 | Татах | |
| 2 | Микрофон | 5 | ш | 2 | 110,000.0 | 220,000.0 | 220,000.0 | 0.0 | Ашиглах боломжгүй | Актлах | 0.0 | Устгах | |
| **Машин тоног төхөөрөмжийн дүн** | | | | | | **11,915,050.0** | **11,915,050.0** | **0.0** | | | 0.0 | | |
| 1 | Үсрэлтийн тавцан | 10 | ш | 3 | 2,420,000.0 | 7,260,000.0 | 7,260,000.0 | 0.0 | Ашиглах боломжгүй | Актлах | 0.0 | Устгах | |
| 2 | Заалны дрож | 5 | ш | 25 | 85,000.0 | 2,125,000.0 | 2,125,000.0 | 0.0 | Ашиглах боломжгүй | Актлах | 0.0 | Устгах | |
| 3 | Хүлээлгийн сандал | 5 | ш | 5 | 380,000.0 | 1,900,000.0 | 1,900,000.0 | 0.0 | Ашиглах боломжгүй | Актлах | 0.0 | Устгах | |
| 4 | Тусгаарлагч | 5 | ш | 4 | 110,000.0 | 440,000.0 | 440,000.0 | 0.0 | Ашиглах боломжгүй | Актлах | 0.0 | Устгах | |
| **Тавилга эд хогшилийн дүн** | | | | | | **11,725,000.0** | **11,725,000.0** | **0.0** | | | | | |
| **Нийт данснаас хасах хөрөнгийн дүн** | | | | | | **23,640,050.0** | **23,640,050.0** | **0.0** | | | | | |
| | Үнээс. Худалдах хөрөнгө | | | | | 0.0 | 0.0 | 0.0 | | | | | |
| | Актлах хөрөнгө | | | | | 11,945,000.0 | 11,945,000.0 | 0.0 | | | | | |
| | Татан төвлөрүүлэн хөрөнгө | | | | | 11,695,050.0 | 11,695,050.0 | 0.0 | | | | | |
| | Худалдсанаас олох орлого | | | | | 0.0 | 0.0 | 0.0 | | | | | |
| | НӨХГ-т төвлөрүүлэх /30%/ | | | | | 0.0 | 0.0 | 0.0 | | | | | |